



**БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ
ИНСТИТУТИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2016 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/77

Улаанбаатар хот

Онлайн сургалт болон мэргэжлийн шалгалтыг давтан зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 180 дугаар тогтоолоор батлагдсан “Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.2.5, 2.2.7, 2.2.8, 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалтыг үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/287 дугаар тушаалаар батлагдсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/305 дугаар тушаалаар батлагдсан “Багшид багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах журам”, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн захирлын 2016 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн шалгалт зохион байгуулах журам”-ыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагад Багшлах эрх шинээр олгуулах болон сунгуулах хүсэлт гаргасан багш нарын онлайн сургалтыг 2016 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс 10 дугаар сарын 12-ны өдрүүдэд, мэргэжлийн шалгалтыг 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдөр тус тус зохион байгуулсугай.

2. “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагад Багшлах эрх шинээр олгуулах болон сунгуулах хүсэлт гаргасан багш нарын багшийн мэргэжил дээшлүүлэх онлайн сургалт болон мэргэжлийн шалгалтыг давтан зохион байгуулах удирдамж”-ыг хавсралтаар баталсугай.

3. Багшийн мэргэжил дээшлүүлэх онлайн сургалт болон мэргэжлийн шалгалтыг давтан зохион байгуулахад удирдамжийн дагуу хамтарч ажиллахыг Нийслэлийн боловсролын газар, Аймгийн боловсрол, соёл, урлагийн газарт үүрэг болгосугай.

4. Уг ажлыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулахыг Цахим сургалтын алба /П.Зохихсүрэн/, Байгалийн ухааны сургалтын алба /Д.Үүрийнтуяа/, Хэл, нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургалтын алба /Ш.Оюунцэцэг/, Сургуулийн өмнөх болон бага боловсролын сургалтын алба /Н.Мөнхбаяр/-уудад тус тус үүрэг болгосугай.

000 00307


5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд захирал /О.Оюунтунгалаг/-д даалгасугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



А.ТУЯА

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн
захирлын 2016 оны 09-р сарын 07-ний өдрийн
А/... дугаар тушаалын хавсралт



Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагад багшлах эрх шинээр олгуулах болон сунгуулах хүсэлт гаргасан багш нарын мэргэжил дээшлүүлэх онлайн сургалт болон мэргэжлийн шалгалтыг давтан зохион байгуулах удирдамж

Нэг. Үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 180 дугаар тогтоолоор батлагдсан “Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.2.5, 2.2.7, 2.2.8 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/305 дугаар тушаалаар батлагдсан “Багшид багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах журам”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/287 дугаар тушаалаар батлагдсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-ыг тус тус үндэслэн Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн захирлын 2016 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн шалгалт зохион байгуулах журам” батлагдан хэрэгжиж эхлээд байна.

Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагад 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй багшлах эрх олгуулах болон сунгуулах хүсэлт гарсан багш нарын үндэсний хэмжээний үндсэн сургалтад хамрагдсан байх шалгуурыг дараах үзүүлэлтээр тооцож байгаа билээ. Үүнд:

- Танхимын сургалт - 20 оноо
- Мэргэжлийн шалгалт:
 - Тест - 25 оноо
 - Эсээ бичих - 15 оноо
- Онлайн сургалт - 40 оноо

Энэхүү үзүүлэлтийн дагуу нийт 100 оноо цуглуулах ба үүний 70 ба түүнээс дээш оноотой багш нар үндсэн сургалтад хамрагдсан байх шалгуурыг хангасанд тооцно.

2016 оны үндсэн сургалтын хамрагдсан байдлаас үзэхэд шалгуур үзүүлтэд хүрч чадахгүй байгаа багш нарт “Мэргэжлийн шалгалт” ба “Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын онлайн сургалт”-ыг давтан зохион байгуулах хэрэгцээ үүссэн билээ.

Хоёр. Мэргэжлийн шалгалт , онлайн сургалтад давтан оролцогчид

Багшлах эрх шинээр олгуулах болон сунгуулах хүсэлт гаргасан багш нарын нийт үнэлгээ 70 оноонд хүрээгүй бол тухайн багш “Мэргэжлийн шалгалт” ба “Онлайн сургалт”-д дахин 1 удаа хамрагдана.

Гурав. Онлайн сургалтын зохион байгуулалт

- 3.1. Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын танхимын хэлбэрээр хамрагдсан батламжтай ба мэргэжлийн шалгалт болон онлайн сургалтын оноогоо ахиулах хүсэлтэй багш нар энэхүү онлайн сургалтад давтан оролцоно.
- 3.2. esurgalt.itpd.mn цахим хаяг дээрх “Багшийн цахим кампус”-т Онлайн давтан сургалтын виртуаль анги үүсгэх бөгөөд суралцагчид нь өмнөх хэрэглэгчийн бүртгэлээрээ нэвтэрч орно. Багшийн цахим кампуст нэвтэрч чадахгүй бол Цахим сургалтын албанд хандаж шийдвэрлүүлнэ.
- 3.3. Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт хариуцсан арга зүйчид онлайн сургалтын ангиудыг судлагдахууныхаа чиглэлээр, Цахим сургалтын албаны арга зүйчидтэй хамтран сургалтыг хөтлөн явуулна.
- 3.4. Давтан сургалтын онлайн ангид бүртгэгдсэн суралцагчид онлайн сургалтын үйл ажиллагаанд 30 хоногийн турш оролцоно.
- 3.5. Давтан сургалтад хамрагдаж буй суралцагч нь өгөгдсөн даалгавруудыг гүйцэтгэж, үнэлгээ авна.
- 3.6. Онлайн сургалтын төгсгөлд Багшлах эрх олгох, сунгах шалгуур үзүүлэлтийн оноог Багшийн цахим кампусын “Онлайн сургалт”-ын ангид хувийн үнэлгээгээр мэдэгдэх болно.

Дөрөв. Мэргэжлийн шалгалтын давтан зохион байгуулалт

- 4.1. Мэргэжлийн давтан шалгалтыг онлайн хэлбэрээр 2016 оны 10 дугаар сарын 26-ны өглөө 10⁰⁰ цагт Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн Цахим сургалтын алба аймаг, нийслэлийн боловсролын газрын мэдээллийн технологийн сургалт хариуцсан мэргэжилтэнтэй хамтарч зохион байгуулна.
- 4.2. Аймгийн боловсрол, соёлын газар, нийслэлийн боловсролын газар орон нутгийн хэмжээнд энэхүү шалгалтын тухай зар мэдээг түгээх, тавигдсан шаардлагын дагуу шалгалтын байр, танхим, тоног төхөөрөмж бэлтгэх, удирдамжийн дагуу орон нутагтаа шалгалтыг шударга, хариуцлагатайгаар зохион байгуулах ажлыг гүйцэтгэнэ.
- 4.3. Мэргэжлийн шалгалтад зөвхөн үндсэн сургалтад хамрагдсан багш нарыг давтан хамруулна. Хоцорсон хүнийг шалгалтад оруулахгүй.
- 4.4. Шалгалт зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг манай байгууллагаас нээж өгсөн [аймаг/дүүрэг/-ийн нэр]@itpd.mn цахим шуудангаар илгээх болно.
- 4.5. Мэргэжлийн шалгалт нь хоёр хэсэгтэй, нийт 40 онооны даалгавартай байна. Нэгдүгээр хэсэг нь тест (25 оноо), хоёрдугаар хэсэг нь эсээ бичих (15 оноо) даалгавар гүйцэтгэнэ.
- 4.6. Шалгалтын тест нь олон хариултаас нэг зөв хариултыг сонгох 25 онооны даалгавар байна. Шалгалтын тест нь дараах бүтэцтэй байна.
 - 4.6.1. Мэргэжлийн онолын асуулт даалгавар – 8 оноо
 - 4.6.2. Мэргэжлийн заах арга зүйн асуулт даалгавар – 10 оноо
 - 4.6.3. Боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлал, салбарын эрх зүйн асуулт даалгавар – 7 оноо
- 4.7. Мэргэжлийн шалгалтын нийт хугацаа 80 минут байна. Үүнээс тестийн шалгалтын хугацаа 30 минут, эсээ бичих хугацаа 50 минут байна.

- 4.8. Шалгалтын явцад шалгуулагч хувийн шалтгаанаар шалгалтын анги, танхимаас гарах бол шалгалтыг дуусгаад тэр хүртэлх гүйцэтгэсэн даалгавраа илгээж шалгалтыг дуусгана.
- 4.9. Эсээ бичлэгийн болон ерөнхий дүнг ажлын 5 хоногт багтаан www.itpd.mn цахим хуудсаар зарлана.
- 4.10. Шалгалтын явцын турш БМДИ-ийн Цахим сургалтын албаны хариуцсан арга зүйчтэй (тусгай) цахим шуудан ба бүртгүүлсэн телефон утсаар холбогдон хамтран ажиллана.

Тав. Шалгалтын хянагч ажилтны эрх, үүрэг

- 5.1. Мэргэжлийн шалгалтын хянагч ажилтан нь аймаг, нийслэлийн боловсролын газрын мэдээлэлзүйн сургалт хариуцсан мэргэжилтэн байна.
- 5.2. Хянагч ажилтан нь шалгалтын байр, танхимыг товлох, бэлтгэл ажлыг хангах ажлыг зохион байгуулна.
- 5.3. Шалгалтад оролцогчдын бичиг баримтыг шалган шалгалтын танхимд оруулах, шалгалт эхлэхээс 10 минутын өмнө шалгуулагчдыг нэрсийн жагсаалтын дагуу компьютерт хуваарилан суулгасан байна.
- 5.4. Шалгалтын явцын талаар тэмдэглэл хөтлөх, шалгалтын дэг, шалгуулагчдын эрх, үүргийг танилцуулна.
- 5.5. Цахим хэлбэрээр шалгалт өгөх зааварчилгаа өгөх, шалгалтын эхлэх болон дуусах хугацааг зарлана.
- 5.6. Шалгуулагчид хяналт тавина.
- 5.7. Шалгуулагч нь шалгалтын журмыг зөрчсөн тохиолдолд тэмдэглэл хөтлөн шалгалтаас хасна.
- 5.8. Шалгалтын явцад техник, тоног төхөөрөмж, програм, шалгалтын системтэй холбоотой асуудал тулгарвал шийдвэрлэх, яаралтай арга хэмжээ авна.
- 5.9. Шалгалтын дундуур гарч явах, утсаар ярихгүй байх
- 5.10. Шалгалтын системд гаднаас өөр хэрэглэгч нэвтрэх боломжийг хязгаарлах
- 5.11. Шалгуулагчид туслах, шалгалтын сэдэв, даалгавартай холбоотой тайлбар хийхгүй байх
- 5.12. Шалгалтын системд ажиллах зааварчилгаа өгөхөөс бусад тохиолдлоор шалгуулагчтай харьцахгүй байх
- 5.13. Шалгалтын хугацаа эхэлснээс хойш шалгалтын байранд гадны хүн оруулахгүй байх

Зургаа. Шалгуулагчийн эрх, үүрэг

- 6.1. Шалгуулагч нь дараах эрхтэй
 - 6.1.1. Шалгалтын систем дээр ажиллах зааварчилгаа авах
 - 6.1.2. Шалгалт эхлэхээс өмнө шалгалт өгөх гэж буй компьютерийн ажиллагааг шалгах
 - 6.1.3. Шалгалт өгөх гэж буй компьютерийг програм болон техникийн шаардлага хангахгүй байгаа тохиолдолд хянагч ажилтанд танилцуулан суудлаа солих
 - 6.1.4. Шалгалттай холбоотой өргөдөл, гомдол, хүсэлт гаргах
- 6.2. Шалгуулагч нь дараах үүрэгтэй

- 6.2.1. Мэргэжлийн шалгалт зохион байгуулах журмыг уншиж танилцсан байх, журмыг дагаж мөрдөх
- 6.2.2. Шалгалтад ирэхдээ иргэний үнэмлэхээ авч ирэх
- 6.2.3. Шалгалт эхлэхээс 30 минутын өмнө шалгалт өгөх байранд ирсэн байх ба шалгалт эхлэхээс 10 минутын өмнө шалгалт өгөх компьютерийн ард сууж бэлэн болсон байх
- 6.2.4. Шалгалтын хянагч ажилтны журмын дагуу зүй ёсны шаардлагыг биелүүлэх
- 6.2.5. Шалгалтын хугацаа эхэлснээс хойш шалгуулагчийн мэдээллийн технологи-компьютер ашиглах суурь чадвараас үүдэх аливаа асуудлыг шалгуулагч өөрөө хариуцах(тухайлбал: шалгалтын системийг хааж програмаас гарах, шалгалтын сэдэвтэй гүйцэд ажиллаж дуусаагүй үед илгээх, шалгалтаа дуусгах, хийж байсан даалгаврын гүйцэтгэлээ устгах зэрэг)

Долоо.Шалгалтын анги, танхимд тавигдах шаардлага

- 7.1. Техник тоног төхөөрөмжийн шаардлага:
 - Компьютер (интернетэд холбогдох боломжтой, бүрэн бүтэн найдвартай ажиллагаатай байх)
 - Интернет (0.3МБ–аас дээш хурдтай, тасалдалгүй байх)
 - Эрчим хүчний найдвартай байдлыг хангасан байх
 - Компьютер хоорондын зай 80см -аас багагүй байх
 - Хэрвээ зөөврийн компьютер хэрэглэсэн бол тусдаа хулгана залгасан байна.
 - Компьютерын гар дээр кирилл монгол үсэг наасан байна.
 - Шалгалтын онлайн системд ажиллах заавар байршуулна.
- 7.2. Програм хангамжид тавигдах шаардлага:
 - Интернет хөтөч (Internet explorer, firefox, chrome эдгээрээс багадаа 2 нь байх)
 - Монгол гарын хөтөч нь unicode -оор бичдэг байх (системийн гарын тохиргоог хийсэн байх)